



## ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ 2019 ОН



ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## ГАРЧИГ

1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ ГА ТАЛБАЙ, ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ.
2. БАЙГАЛ ЦАГ УУРЫН ОНЦЛОГ
3. СУМ, ХОРООД, ӨРХ ХҮН АМЫН ТОО
4. НАС ХҮЙС
5. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ
6. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН
7. АЖИЛ ЭРХЛЭЛТ, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР
8. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ
9. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ
10. СҮМ ХИЙД
11. БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГА
12. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ
13. ЭРГҮҮЛИЙН НЭГДСЭН БАЙРШИЛ
14. ЗАМЫН ХЯНАЛТЫН ЦЭГ БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙН ХЯНАЛТЫН КАМЕР
15. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



### ДУНДГОВЬ АЙМГИЙН ТҮҮХ

Дундговь аймаг нь 1941 онд Өмнөговь аймгаас 8 сум, Дорноговь аймгаас 3 сум, Төв аймгаас 7 сум тус тус шилжүүлэн 18 сумтайгаар одоогийн Өлзийт сумын нутаг Ембүү дэрсэнэ ус гэдэг газар Шарангад аймаг нэртэйгээр байгуулагдаж 1942 онд аймгийн нэрийг Дундговь болгон өөрчилж аймгийн төвийг одоогийн оршин байгаа Зоогийн Хар овооны энгэрт 15 сум 66 багатайгаар суурьшсан байна. Нутгийн баруунаас зүүн цэг хүртэл 425 км, хойноос урд цэг хүртэл 238 км, бүгд 7469,0 мянган га нутаг дэвсгэртэй газар нутгийн хэмжээгээр Монгол улсын улсын нутаг дэвсгэрийн 4,5%-ийг эзэлдэг, аймгийн төв нь Мандалговь хот, нийслэл Улаанбаатар хотоос 280 км зайд оршдог.

Өвөрхангай, Төв, Говь-Сүмбэр, Дорноговь, Өмнөговь аймгуудын нийт 16 сумын нутагтай 1230 километрээр хиллэдэг. Тэгш тал газрын хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1530м, хамгийн нам цэг нь 980м өндөрт өргөгдсөн. Хамгийн өндөр нь Дэлгэрхангайн уул бөгөөд далайн түвшнээс дээш 1913м өндөрт өргөгдсөн байдаг. Тус аймгийн нутагт уулын хөрс /хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн/ маш бага хувын эзэлж Адаацагийн хойд тал, Бага газрын чулуун, Угтаал-Уул, Их газрын чулуун орчимд тархсан, Нутгийн төв, хойд хэсгээр ухаа толгод нам уулсын /хүрэн, цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, хээржүү цөлийн бор/ хөрс, нутгийн төв, өмнөд хэсгээр тал хөндий /цөлөрхөг хээрийн 20 төрлийн хөрс/ хөрс тархсан.

### ДУНДГОВЬ АЙМГИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Дундговь аймгийн агаарын дундаж температур сүүлийн 30 жилийн байдлаар 0.5 градусаар, сүүлийн 10 жилд 1.1 градусаар дулаарсан. Хамгийн дулаан 10 жил нь 2004, 2006, 2007, 2008, 2013, 2014, 2015, 2017, 2018, 2019 онууд байлаа.

Дундговь аймгийн хувьд 2-р 10 жилд уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдсан гэж үзэхээр байна.

Дундговь аймгийн 1990-2019 оны агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулан үзэхэд нутгийн өмнөд хэсгээр буюу цөлжилттэй бүс нутгаар илүү эрчимтэй дулаарсан байна.

Сүүлийн жилүүдэд хур тунадасны хэмжээ өсч буй нь харагдаж байна. Энэ нь халалтын улмаар үүсдэг конвекцийн үзэгдлийн нэг болох дуу цахилгаантай аадар бороо орох нь ихэссэн мөн нөгөө талаасаа 2008 оноос цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй шууд холбоотой юм.

Мөн сүүлийн жилүүдэд цаг агаарын аюулт үзэгдлийн тоо өсөх хандлагатай бөгөөд ялангуяа хүчтэй салхитай өдрийн тоо, шороон шуургатай өдрийн тоо, конвекцийн үзэгдэл буюу нөөлөг салхи, хүчтэй аадар бороо ихсэж улс нийгэмд учруулах хохирлын хэмжээ ч өссөөр байна.

#### СУМДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ-2019

Сумд	нутаг дэвсгэр /мян. га-гаар /	Багийн тоо	өрхийн тоо	хүн амын тоо / суурин хүн амаар/	Шилэн кабельд холбогдсон	малын тоо / мян. тол /	УБ-аас сум хүртэлх зай км	Аймгийн төвөөс сум хүртэлх зай км
Дэлгэрцогт	250.2	3	561	1639	+	199,5	233	42
Дэрэн	362.4	4	608	2118	+	279	235	72
Говь-Угтаал	270.7	4	496	1542	+	208	249	107
Цагаандэлгэр	342.8	4	398	1017	+	152,4	206	160
Баянжаргалан	318.9	3	454	1261	+	157,3	289	143
Өндөршил	485.2	3	466	1388	+	189,7	355	182
Гурвансайхан	541.6	5	658	2140	+	313,2	322	71
Өлзийт	1542.1	6	752	2360	-	369,8	371	86
Хулд	607	4	717	2372	+	295,8	356	81
Луус	316	3	562	1863	+	193,9	327	52
Дэлгэрхангай	620.9	4	671	2292	+	220,4	362	134
Сайхан-Овоо	405.5	4	660	2111	+	207,0	392	213
Эрдэнэдалай	735.1	7	1663	5806	+	586,1	274	114
Сайнцагаан	340.6	9	4734	15716	+	417,5	275	0
Адаацаг	330	5	794	2812	+	303,5	211	85
<b>Дүн</b>	<b>7469</b>	<b>68</b>	<b>14194</b>	<b>46437</b>		<b>4093.7</b>	<b>-</b>	<b>-</b>

#### БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗРУУД

Эртний далайн ёроолын үлдэц бүхий Өлзийт сумын нутаг Цагаан суварга, Морин толгойн цав, Өөш манхан зэрэг өвөрмөц тогтоцтой шавар цав, элсэн манхан, Их газрын чулуу, Бага газрын чулуу зэрэг боржин чулуун уул, заг, хайлаас, бударгана бүхий олон арван өргөн уудам говь бий.

Өлзийт сумын загийн усан хоолой, Гурвансайхан, Говь-Угтаал сумын Их газрын чулуу, Дэлгэрхангай сумын Дэлгэрхангай уулыг улсын нөөц газраар, Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны уулыг байгалийн дурсгалт газраар улсын тусгай хамгаалалтад авсан.

Мөн аймгийн тусгай хамгаалалттай Адаацаг сумын Сүм хөх бүрд, Өлзийт сумын өөш манхан, Цагаансуварга, Баянжаргалан сумын Аргийн хад, Хүрэн дух, Сайнцагаан сумын Тогоогийн хужир, Өлзийт сумын дэл хөнжил уул, Сайхан-Овоо сумын Онгийн хийд зэрэг 100,0 мянга гаруй га газар байна. Эдгээр газруудыг түшиглэж аялал жуулчдын бааз нээн нийт 15 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна.



2019 оны 1 сарын 1-ны байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 13 сумын нутагт 98, хайгуулын тусгай зөвшөөрөл 12 сумын нутагт 115, нийт 213 тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд эдгээрийн нийт талбайн хэмжээ 783 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 10.5 хувийг эзэлж байна.

Ашиглалт хайгуулын зөвшөөрөл олгосон байдал /сумаар/

Сумын нэр	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Хайгуулын тусгай зөвшөөрөл		Бүгд	Талбайн хэмжээ Мян.га	Газар нутгийн хэдэн хувийг эзлэх
	тоо	Талбай	тоо	Талбай			
		Мян.га		Мян.га			
1.Дэлгэрцогт					0	0	0.00
2.Дэрэн			3	6.3	3	6.3	1.73
3.Говь-Угтаал	11	5.1	3	3.9	14	9	3.31
4.Цагаандэлгэр	3	4.4	6	11	9	15.4	4.44
5.Баянжаргалан	29	22.2	11	24.2	40	46.4	14.50
6.Өндөршил	7	30.7	20	142	27	172.7	35.45
7.Гурвансайхан	13	49	13	62.7	26	111.7	20.44
8.Өлзийт	9	19	30	135.1	39	154.1	9.95
9.Хулд	4	4.3	20	126.3	24	130.6	21.44

10.Луус	2	0.2	10	46.7	12	46.9	14.82
11.Дэлгэрхангай	19	8.3	11	55.4	30	63.7	10.24
12.Сайхан-Овоо	1	1.4			1	1.4	0.34
13.Эрдэнэдалай	6	5.8	6	12.5	12	18.3	2.49
14.Сайнцагаан	6	5.3			6	5.3	1.58
15.Адаацаг	3	0.2	1	1	4	1.2	0.36
<b>Дүн/давхардсан тоогоор/</b>	<b>113</b>	<b>155.9</b>	<b>134</b>	<b>627.1</b>	<b>247</b>	<b>783.0</b>	<b>10.5</b>
<b>Давхардаагүй тоогоор</b>	<b>98</b>	<b>155.9</b>	<b>115</b>	<b>627.1</b>	<b>213</b>	<b>783.0</b>	<b>10.5</b>

Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 10 ломбард, 5 банк санхүүгийн байгууллага, уламжлалт шашины 8 хийд байгаагаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 4 хийд, 1 музейд тус бүр харуул хамгаалалт, камер хяналт, гадна орчны гэрэлтүүлэгээ сайжруулах талаар хугацаатай албан мэдэгдэл хүргүүлж үр дүнг тооцон ажиллаж байна.

Эртний булш бунхан, туурь балгас ухаж сүйтгэх гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор нутаг дэвсгэртээ байгаа эртний нуугдмал эд зүйлс, эд баялаг агуулагдаж байж болзошгүй газар орны бүртгэлд авч хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд шинээр бүртгэгдсэн газар байхгүй, өмнө нь бүртгэгдсэн булш оршуулгын дурсгалт газар 1392, чулуун зэвсгийн дурсгалт газар 2, хадны зураг, бичгийн дурсгалт газар 37, хөшөө дурсгалт газар 7, хийдийн туйр 44-ийг аймгийн музей, сумдын идэвхтэн байгаль хамгаалагч, нутгийн иргэдтэй хамтран хяналт тавин ажиллаж байна.

#### ХҮН АМЫН МЭДЭЭЛЭЛ


Аймгийн суурин хүн амын тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 46437 болж, өмнөх оноос 383 хүнээр буюу 0.82 хувиар буурсан байна. Энэ нь Монгол улсын суурин хүн амын 1.4 хувийг эзэлж байна. Суурин хүн амын тоонд өөр аймаг, нийслэл болон гадаадад 6-аас дээш сараар амьдарч байгаа иргэдийг оруулж тооцоогүй бөгөөд тухайн аймгаас гадаадад 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа иргэд 418 байна.



2019 оны байдлаар нийт хүн амын 30.4 хувийг 0-14 насны хүүхэд, 64.3 хувийг 15-64 насныхан буюу хөдөлмөрийн насны хүн ам, 5.3 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад нийт хүн амын дунд 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувь 0.7 пунктээр өсч, 15-64 насны хүн амын эзлэх хувь 1.5 пунктээр буурсан харагдаж байна.

Хүн амын хүйсийн харьцааг сүүлийн жилүүдээр харьцуулж үзвэл 2011 он хүртэл 100 эмэгтэй тутамд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99.4-99.9 байж, нийт хүн амын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байсан бол 2012 оноос хойш нийт хүн амын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өсч 2019 оны эцсийн байдлаар 101.6 болсон байна. Энэ нь 100 эмэгтэй тутамд 102 эрэгтэй ногдож байгааг харуулж байгаа бөгөөд тус аймгийн хувьд хүйсийн харьцаа нийт дүнгээрээ хэвийн байна.

### Хүйсийн харьцаа, 2000-2019




Хүйсийн харьцааг насны ангилал тус бүрээр тодорхой харуулсан үзүүлэлт бол нас хүйсийн суварга юм. Дараах нас хүйсийн суваргаас харвал нийт хүн амын дунд 0- 4 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж хүйсийн харьцаа хэвийн байна.

Нас хүйсийн суваргын дунд хэсгээр цүлхийсэн байгаа нь нийт хүн амын дунд 15-64 насны идэр насныхан гол хэсгийг бүрдүүлж байна. Насны бүлэг тус бүрд хүйсийн харьцаа хэвийн байгаа бол 50 болон түүнээс дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгаа нь 50 болон түүнээс дээш насанд эрэгтэйчүүдийн нас баралт илүү байгааг харуулж байна. /Зураг 10. Аймгийн 2019 оны хүн ам нас хүйсийн суварга/

## Хүн ам нас хүйсийн суварга-2019

■ эмэгтэй ■ эрэгтэй




Дундговь аймгийн сумдуудын хүн амын тоо 2010-2019 онуудаар

СУМ	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
ДЭЛГЭРЦОГТ	1713	1628	1591	1547	1552	1575	1616	1677	1694	1639
ДЭРЭН	2213	2138	2058	2022	2026	2053	2065	2080	2105	2118
ГОВЬ-УГТААЛ	1598	1565	1544	1532	1564	1043	1586	1591	1586	1542
ЦАГААНДЭЛГЭР	1023	1011	974	979	1003	1013	1005	1047	1058	1017
БАЯНЖАРГАЛАН	1177	1161	1168	1180	1178	1197	1168	1195	1276	1261
ӨНДӨРШИЛ	1548	1500	1504	1475	1443	1433	1446	1421	1421	1388
ГУРВАНСАЙХАН	2272	2214	2149	2111	2095	2098	2088	2149	2093	2140
ӨЛЗИЙТ	2389	2315	2264	2233	2295	2345	2386	2352	2363	2360
ХУЛД	2274	2275	2298	2347	2352	2322	2379	2422	2416	2372
ЛУУС	2047	1986	1932	1892	1822	1805	1776	1827	1864	1863
ДЭЛГЭРХАНГАЙ	2385	2295	2223	2177	2148	2177	2209	2279	2291	2292
САЙХАН-ОВОО	2537	2501	2375	2307	2220	2186	2144	2180	2156	2111
ЭРДЭНЭДАЛАЙ	6141	6020	5841	5765	5642	5690	5701	5730	5847	5806
САЙНЦАГААН	1350	1340	1364	1388	1400	1460	1512	1550	1576	1571
	9	5	3	6	8	2	0	8	2	6
АДААЦАГ	3088	3034	3037	2947	2859	1841	2826	2925	2888	2812
ДҮН	4591	4504	4460	4440	4420	4338	4551	4638	4682	4643
	4	8	1	0	7	0	5	3	0	7

Дундговь аймгийн Сайнцагаан, Эрдэнэдалай сумаас бусад суманд дунджаар 1917 хүн амьдарч байна. Хүн амын тоогоор Сайнцагаан сум хамгийн олон буюу 15176, Цагаандэлгэр сум хамгийн цөөн буюу 1017 байна.

Зураг.2

АЙМГИЙН НИЙТ ӨРХ, ҮҮНЭЭС МАЛЧИН ӨРХ



## ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО, ӨРХИЙН ТОО /2015-2019/



### Хүснэгт 1.Өрхийн тоо, сууцны төрөл, хот, хөдөөгөөр

		Хот, Хөдөө		
		Бүгд	Хот	Хөдөө
Гэр, Байшин, Бусад сууц	Бүгд	14212	3726	10486
	Гэр	11091	2046	9045
	Байшин	3026	1650	1376
	Бусад сууц	95	30	65
Байшингийн төрөл	Бүгд	3026	1650	1376
	Нийтийн зориулалттай орон сууцны байшин	906	822	84
	Бие даасан тохилог сууц	187	168	19
	Сууцны тусдаа байшин	1755	647	1108
	Нийтийн байр	178	13	165

### Төрсөн хүүхдийн тоо 2015-2019 онуудаар

СУМ	2015	2016	2017	2018	2019
ДЭЛГЭРЦОГТ	42	35	39	48	24
ДЭРЭН	59	46	43	52	67
ГОВЬ-УГТААЛ	42	29	32	40	38
ЦАГААНДЭЛГЭР	20	28	15	22	23
БАЯНЖАРГАЛАН	22	32	31	33	32
ӨНДӨРШИЛ	22	31	24	26	30
ГУРВАНСАЙХАН	45	42	43	42	51
ӨЛЗИЙТ	62	54	51	41	62
ХУЛД	63	68	66	67	57

ЛУУС	45	39	38	57	36
ДЭЛГЭРХАНГАЙ	55	40	51	68	64
САЙХАН-ОВОО	48	55	38	42	38
ЭРДЭНЭДАЛАЙ	153	143	142	152	173
САЙНЦАГААН	357	397	339	438	416
АДААЦАГ	60	68	70	64	77
ДҮН	1095	1107	1022	1192	1188

Нас барсан хүний тоо 2015-2019 он

СУМ	2015	2016	2017	2018	2019
ДЭЛГЭРЦОГТ	13	11	8	14	10
ДЭРЭН	9	17	11	11	10
ГОВЬ-УГТААЛ	16	16	12	12	9
ЦАГААНДЭЛГЭР	7	11	5	7	4
БАЯНЖАРГАЛАН	7	5	4	9	9
ӨНДӨРШИЛ	7	12	7	5	11
ГУРВАНСАЙХАН	18	9	12	16	15
ӨЛЗИЙТ	9	17	10	13	12
ХУЛД	11	14	11	9	13
ЛУУС	18	11	7	16	15
ДЭЛГЭРХАНГАЙ	15	19	17	25	21
САЙХАН-ОВОО	15	11	13	8	15
ЭРДЭНЭДАЛАЙ	39	51	32	36	51
САЙНЦАГААН	103	90	81	111	95
АДААЦАГ	29	20	18	21	25
ДҮН	316	314	248	313	315

ДУНДГОВЬ АЙМГААС ӨӨР АЙМАГ, ХОТОД ШИЛЖИН ЯВСАН ХҮН АМЫН ТОО,  
СУМДААР, 2010-2019 ОН

Сумын нэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
БҮГД	2432	1785	1370	1629	1450	1152	1155	609	595	728
Дэлгэрцогт	152	122	61	79	62	52	41	23	29	25
Дэрэн	137	103	67	66	67	54	39	32	19	36
Говь-Угтаал	58	58	62	43	39	44	41	34	9	38
Цагаандэлгэр	170	40	51	45	44	39	50	24	18	35
Баянжаргалан	60	55	26	54	67	27	70	37	50	29

Өндөршил	80	75	33	62	65	25	31	44	19	34
Гурвансайхан	113	70	64	90	41	51	43	17	23	27
Өлзийт	121	63	73	85	35	34	56	47	15	50
Хулд	139	51	33	45	44	32	33	19	28	39
Луус	63	61	47	48	54	33	41	26	15	16
Дэлгэрхангай	86	73	77	87	65	57	46	12	31	31
Сайхан-Овоо	128	77	111	68	116	96	75	46	28	35
Эрдэнэдалай	398	230	162	215	219	177	155	64	74	57
Сайнцагаан	603	588	444	505	415	332	351	165	209	221
Адаацаг	124	119	59	137	117	99	83	19	28	55

**ДУНДГОВЬ АЙМАГТ ӨӨР АЙМАГ, ХОТООС ШИЛЖИН ИРСЭН ХҮН АМЫН ТОО,  
СУМДААР, 2010-2019 ОН**

Сумын нэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
<b>БҮГД</b>	<b>211</b>	<b>220</b>	<b>285</b>	<b>618</b>	<b>669</b>	<b>792</b>	<b>701</b>	<b>777</b>	<b>638</b>	<b>545</b>
Дэлгэрцогт	25	17	7	25	39	33	45	32	31	25
Дэрэн	21	6	3	14	35	32	30	40	19	21
Говь-Угтаал	26	12	14	37	18	32	17	37	7	12
Цагаандэлгэр	4	4	4	35	37	22	21	17	21	24
Баянжаргалан	21	19	11	23	44	29	26	28	51	33
Өндөршил	12	7	7	30	19	14	19	19	18	16
Гурвансайхан	2	10	9	12	21	34	20	33	21	24
Өлзийт	7	6	9	19	32	32	45	38	15	34
Хулд	7	28	10	67	24	37	30	32	29	22
Луус	7	9	15	20	10	33	26	25	14	20
Дэлгэрхангай	0	8	12	34	36	34	38	54	29	30
Сайхан-Овоо	7	13	6	19	20	27	29	39	30	31
Эрдэнэдалай	33	27	35	45	67	50	72	63	79	61
Сайнцагаан	21	47	130	219	228	347	243	262	246	177
Адаацаг	18	7	13	19	39	36	40	58	28	15

## ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР




## ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Гэрт амьдардаг өрхийг байршлаар нь харахад аймгийн төвд оршин суудаг өрхийн 71.1 хувь, сумын төвд оршин суудаг өрхийн 77.4 хувь, хөдөөгийн өрхийн 98.5 хувь нь гэрт амьдарч байна.

Сууцны төрөл	2010		2020	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	10895	100	14212	100
Гэр	8974	82.4	11091	78
Бусад сууц	49	0.4	95	0.7
Байшин	1872	17.2	3026	21.3
Орон сууцны байшин	460	4.2	906	6.4
Бие даасан тохилог сууц	48	0.4	187	1.3
Сууцны тусдаа байшин	1160	10.7	1755	12.3
Нийтийн байр	204	1.9	178	1.3

## НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД 5 ЖИЛЭЭР

■ 2015 ■ 2016 ■ 2017 ■ 2018 ■ 2019



## МӨНГӨ, БАНК - 2019 ОН

- Нийт хадгаламжийн үлдэгдэл
  - 67 676.5 (сая.төг)
- Зээлийн өрийн үлдэгдэл
  - 116 441.5 (сая.төг)
- Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл
  - 1267.2 (сая.төг)



## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО 2015- 019 ОН

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014
<b>Нийт орлого /тусламжийн дүн/</b>	<b>3759343.7</b>	<b>5276190.6</b>	<b>7437676</b>	<b>35993522</b>	<b>40384378</b>
<b>А.УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>2760541.4</b>	<b>3176426.7</b>	<b>4180485.6</b>	<b>3586934.3</b>	<b>4066699.8</b>
<b>I.ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>2641795.3</b>	<b>2960007</b>	<b>3842246.9</b>	<b>3196424.8</b>	<b>3401636.3</b>
<b>1.1 Хүн амын орлогын албан татвар</b>	<b>1037608.8</b>	<b>1389391.5</b>	<b>2124028</b>	<b>2524674.8</b>	<b>2769870.3</b>
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	957406	1240170.3	1881196.9	2392385.8	2817005
<b>Хувь хүний орлогын албан татварын буцаалт</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-235014.3</b>	<b>-328874</b>
1.2 үйл ажиллагааны орлого	0	0	0	0	0
1.3 Хөрөнгө борлуулсаны	0	0	0	0	0
1.4 Бусад татвар	1037608.8	149221.2	242831.1	367303.3	281739.3
<b>2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/</b>	<b>33224.3</b>	<b>35500.8</b>	<b>95254.1</b>	<b>58092.1</b>	<b>70050.99</b>

<b>3. Авто тээврийн хэрэгслийн</b>	<b>132355.6</b>	<b>175684</b>	<b>200916.4</b>	<b>219559.5</b>	237580.6
<b>4. Бусад татвар</b>	<b>1438606.6</b>	<b>1359430.7</b>	<b>1422048.4</b>	<b>384098.4</b>	<b>324134.39</b>
4.1 Улсын тэмдэгтийн	23014.3	59194.6	58140	108042.3	78624.4
4.2 Ашигт малтмал нөөцийн	368050.1	277713.3	233188	77053.5	44203.5
4.3 Газрын төлбөр	71825.7	119990.4	270467.9	145810.6	151044.5
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	57839.1	21975.6	25488.3	0	6400
4.6 Усны төлбөр	9787.8	38713.8	37255.4	27150.8	25861.99
4.7 Лиценцийн төлбөр	812166.8	809059.1	732998.2	0	0
4.6.Бусад	95922.8	32783.9	64510.6	26041.2	18000
<b>II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>118746.1</b>	<b>216419.7</b>	<b>338238.7</b>	<b>390509.5</b>	<b>665063.5</b>
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	39958.1	64645.1	51150.7	41674.7	347937
2.2 Бусад нэр заагдаагүй	78788	151774.6	287088	348834.83	317126.5
<b>Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	182589.2	80469.8	172284.6	187042.2	419460
<b>В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>816213.1</b>	<b>2019294.1</b>	<b>3084905.8</b>	<b>32219545</b>	<b>35898218</b>
1. Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	816213.1	2019294.1	3084905.8	7210785.4	8094821.7
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0	0	0	17821095	20412495
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих	0	0	0	7187664.8	7390901.6
Хандив тусламж	0	0	0	0	0
2. Аймгаас авсан санхүүгийн дэмжлэг	1489006	1982302.7	2856260.7	6300868.5	0
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	<b>2943130.6</b>	<b>2960007.0</b>	<b>4352770.2</b>	<b>3773976.5</b>	<b>4486159.8</b>
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	990179.6	1080156.3	827448.5	2717494.8	1736039.6
Аймгийн нийт орлого	<b>3933310.2</b>	<b>4040163.3</b>	<b>5180218.7</b>	<b>6491471.3</b>	<b>6222199.4</b>

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА 2015-2019 ОН

Зарлагын төрөл	2015	2016	2017	2018	2019
Орон нутгийн байгууллагын зарлагын дүн	39752111.2	39588999.1	39968852.9	40389222	44241185
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18309510.6	18278314.7	18417961.5	19124965.8	23697435.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1988522.59	1993762.5	2036729.9	2308766.5	2999552.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2596093.6	3231302.7	3298171.6	3525754.6	4233889.4
Хангамж бараа материалын зардал	711412.8	707401.4	807638.4	987183.4	1188356.5
Норматив зардал	1208442.4	1391825.4	1435382.8	1336455.7	1660844.6
Эд хогшил урсгал засварын зардал	305705.59	284939.9	673448.6	1008015.2	1295005.3
Томилолтын зардал	169715.8	148031.7	170379.7	194753.1	400232.6

<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	607098.98	902105.5	852393.0	1100280.1	1630644
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	669465.4	2045680.7	2644263.2	1930032.8	1410003.3
<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>					234894.1
<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	228956.7	205638.4	205032.4	259030.1	0
-Нийгмийн халамжийн үйлчилгээ	0	0	0.0	0.0	
-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал дэмжлэг	0	0	0.0	0.0	
-Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж дэмжлэг	0	0	0.0	0.0	
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4769842.4	4822378.5	6317463.7	5198850.8	612703.2
<b>Хөрөнгийн зардал</b>	8187344.3	5577617.7	3109988.1	3415133.9	3151599.4
<b>Эргэж төлөгдөх зээл</b>	0	0	0	0	1726024.8

### ТЭЭВЭР -2019

- Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машин бү
  - 7821
- Суудлын авто машин
  - 4566
- Ачааны машин
  - 3043
- Автобус
  - 125
- Тусгай зориулалтын
  - 53
  - Ашигласан хугацаагаар: 3 жил хүртэл 78
  - 4-9 жил 997
  - 10-аас дээш жил 6746



### СОЁЛ, СҮМ ХИЙД-2019

- Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сан 128
- Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо 173
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчид 58800
- Нийтийн номын сан 15
- Нийтийн номын сангийн суудал 346
- Номын сангийн байнгын уншигчид 6237
- Сүм хийд 8
  - Будда 6
  - Христ 2





## БАЙГАЛЬ ОРЧИН

- Ойн сан бүхий газар 68.7 (мян.га)
  - Ойн модоор бүрхэгдсэн газар 27.1
  - Ой модыг огтолсон газар 0
  - Мод үржүүлгийн газар 10.3
  - Ой тэлэн ургах нөөц газар 33.0
  - Ойн сангийн бусад газар 0
- Гадаргын ус нийт гол горхи 1
  - Тасарсан 0
  - Ширгэсэн 0
- Рашаан нийт 4
- Булаг 125
  - Ширгэсэн 10
- Нуур, тойром 10
  - Ширгэсэн



## БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

	2015	2016	2017	2018	2019
Сайнцагаан	463	494	535	583	607
Адаацаг	32	33	34	35	34
Баянжаргалан	24	25	28	36	47
Говь-Угтаал	21	22	23	24	26
Гурвансайхан	25	26	28	38	41
Дэлгэрхангай	34	34	35	37	39
Дэлгэрцогт	23	23	23	24	24
Дэрэн	20	21	22	22	22
Луус	18	20	21	28	34
Өлзийт	30	31	32	35	40
Өндөршил	35	38	41	42	46
Сайхан-Овоо	33	35	36	36	38
Хулд	37	38	39	45	45
Цагаандэлгэр	17	18	19	20	21
Эрдэнэдалай	49	49	49	52	54
Дүн	861	907	965	1057	1118

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2015 – 2019 ОН

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Хөдөлмөрийн насны хүн ам	29.8	30.1	30.5	30.5	30.5
Ажиллах хүч	21.2	22.2	23.7	24.5	23.2
Ажиллагчид	20.1	21.1	22.6	23.3	22.0
Ажилгүй иргэд	1162	1133	1034	1218	1147
Эмэгтэй	467	377	325	584	847
Бүртгэлтэй ажилгүй иргэд	512	519	633	487	448
Эмэгтэй	281	293	307	264	224
Ажиллах хүчний оролцооны түвшин	73.1	73.7	77.7	79.6	78.4
Ажилгүйдлийн түвшин	5.5	5.1	4.4	5.0	4.9
Хөдөлмөр эрхлэлийн түвшин	67.4	70.1	74.1	75.6	71.1

### ЭРГҮҮЛИЙН НЭГДСЭН БАЙРШИЛ

Зорилго нь: Аймгийн төвийн гудамж талбай, үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал, орон сууц зэрэг олон нийтийн газарт хэв журам сахиулах, ард иргэдийн амгалан тайван байдлыг хангахад чиглэгдэнэ.

1. Цагдаагийн газраас аймгийн төвд өдөр, оройн гэсэн 2 ээлжээр нийт 9 чиглэлд өдөрт 7-оос доошгүй алба хаагч ажиллана.
2. Аймгийн төвийн хэмжээнд 3 чиглэлийг 8 цагаар, 6 чиглэлийг 8 цагаар цагдаагийн эргүүлийн байнгын хяналтад авахаар зохион байгуулав.
3. Эргүүлийг цаг агаарын хэт халуун болон байгаль цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд тухайн нөхцөл байдлаас хамааран алба хаагчдын ажиллах хугацааг богиносгон 4 цагаас хэтрүүлэхгүй байхаар бодож, ээлжийн зохион байгуулалтад оруулах арга хэмжээ авна.
4. Эргүүлийн үйл ажиллагаанд цагдаагийн газрын дарга сард 2-оос доошгүй удаа, дэд дарга, тасаг албадын дарга нар 7 хоногт 1-ээс доошгүй удаа, нэгжийн дарга, ахлах байцаагч, ёс журмын эргүүлүүд, хариуцлагатай зохицуулагч нар өдөр тутам хяналт тавьж ажиллана.
5. Эргүүлийг эргүүл харуулын дүрэмд хориглосон аргаар шалгахыг хориглоно.
6. Эргүүлийн нэгдсэн байршилтад албан байгууллага, АА-н нэгж 124, үзвэр үйлчилгээний газар 2, сургууль, цэцэрлэг 10, дэлгүүр 35, зочид буудал, зоогийн газар, баар ресторан кафе 11, тоглоомын газар 1, ШТСтанц 6, банкны салбарууд 5, хүнс түүхий эдийн зах 2 зэрэг газрууд хамрагдсан болно.
7. Сумдаас ирсэн хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг аймгийн төвд ажиллах үед нь оройн эргүүлд ажиллуулж болно.
8. Цагдаагийн газраас өдөр, шөнийн ээлжинд ажиллах эргүүлийн чиглэлийн товъёог:

д/д	нэр	Өдрийн эргүүл		Шөнийн эргүүл	
		Чиглэл	Цагдаа	Чиглэл	Офицер, цагдаа

1	Дундговь ЦГ	3	4	6	8
2	Нийт дүн	3	4	6	8

Тайлбар: Цагдаагийн газраас ажиллаж байгаа эргүүлүүд удирдлагаас батлагдсан томилгоогоор ажиллах ба томилгоонд амрах хуваарийг тухай бүрт зааж өгнө.

### Байршилт №1 Өдрийн эргүүл

Аймгийн төвд Цагдаагийн газрын өдрийн эргүүл 12:00-16:00, 16:00-20:00 цаг хүртэл нийт 3 чиглэлд 4 цагдаа ажиллана.

**Чиглэл 1.** Аймгийн ЗДТГ, Мобиком, “Говийн отог”, Сайнцагаан сумын ЗДТГ, ХААН банк, УЦУОШТөв, Монгол банк, Төрийн банк, Хас банк, МЦХ, “Ундром” ХХК, “Бөхт” ХХК, “Хөрх булаг” ХХК, “Гандалай” ХХК, “Ялгуум билэгт” ХХК, Аймгийн Прокурорын газар, “Бүрд зочид буудал, Нэгдсэн эмнэлэг, хүнсний зах, “Өлзий Дундговь” ХХК, ТХДЖ театр, Эрүүл мэндийн газар. 1-р цэцэрлэг, “Цантын булаг” ХХК, “Монос” эм ханган нийлүүлэх, музей, “Мандал” зочид буудал, Татварын хэлтэс, Стандартчилал хэмжилзүй, БГХӨТ төв

**Чиглэл 2.** МСҮТ, Эрдмийн далай цогцолбор сургууль, багш нарын байр, Нарлаг хороолол, баруун цагаан дэлгүүр, “Номгон рашаан” ХХК, МГСС, Онцгой байдлын газар, Сайнцагаан сумын 4, 6-р цэцэрлэг

**Чиглэл 3.** “Говь” буудал, “Говийн ирээдүй” цогцолбор сургууль, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Дашгэмпилэн хийд, Зүүн цагаан дэлгүүрийн орчин, “Боржигон мандал” өрхийн эмнэлэг, Малчны хороолол, “МТ” ШТС, “БМБХ” ХХК, Сайнцагаан сумын 2, 3-р цэцэрлэг, “Говийн тэнгэр” зочид буудал, “Мандалговь хүнс” ХХК, “Тэмүжин” зочид буудал, ЦТСүлжээ, “Нитро” баар, “Ариун болор” ШТС, “Шунхлай” ШТС, “Хайрхан” бөөний төв, Тээврийн хэрэгслийн бүртгэл, оношлогооны газар.

### Байршилт №2

Цагдаагийн газраас оройн эргүүлд 17:00-01:00 цаг хүртэл нийт 6 чиглэлд 8 алба хаагч ажиллана.

**Чиглэл 1.** Аймгийн ЗДТГ, Мобиком, “Говийн отог” баар, Сайнцагаан сумын ЗДТГ, ХААН банк, УЦУОШТөв, Монгол банк, “Өлзий Дундговь” ХХК, “Ундром” ХХК, “Бөхт” ХХК, “Хөрх булаг” ХХК, “Гандалай” ХХК, “Ялгуум билэгт” ХХК, ТХДЖ театр, Эрүүл мэндийн газар, халуун ус, музей, “НИК” ШТС, захын орчин

**Чиглэл 2.** Мандал хорооллын бүх гудамж, МСҮТ, Эрдмийн далай цогцолбор сургууль, багш нарын байр, “Номгон рашаан” ХХК, МГСС, дотуур байрууд, Нефтийн байр, “Жаст-ойл” ШТС,

**Чиглэл-3.** Баруун цагаан дэлгүүр түүний орчин, Айраг хороолол, ОБ Хэлтэс, Соёл амралтын хүрээлэн, 30 айлын сууц, түүний эргэн тойрны орчин Байгаль орчин аялал жуулчлалын газар

**Чиглэл-4.** Хүнсний 36,48-р байр, 26а,б,в,г байрууд, Говийн тэнгэр” зочид буудал, “Мандалговь хүнс” ХХК, “Тэмүжин” зочид буудал, ЦТСүлжээ, “Нитро” баар, “Ариун болор” ШТС, “Шунхлай” ШТС, “Хайрхан” бөөний төв, Тээврийн хэрэгслийн бүртгэл, оношлогооны газар, “Номин” зочид буудал, аймгийн Шүүх, “Алтанговь” зочид буудал, спорт заал, ХАА-н газар, Өвсний фонд, 10,11-р байрууд

**Чиглэл-5.** Эрчмийн 1-3-р гудамж, Боржигоны 1-10-р гудамж, Малчны хороолол, Сүрьеэгийн байр, ЗХ-ний 278-р байгууламж, Сайнцагаан сумын 3-р цэцэрлэг, “БМБХ” ХХК

**Чиглэл-6.** “Говь” буудал, “Говийн ирээдүй” цогцолбор сургууль, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Дашгэмпилэн хийд, Зүүн цагаан дэлгүүрийн орчин, “МТ” ШТС, Сайнцагаан сумын 2-р цэцэрлэг, “Мандалговийн наран” ХХК, Хар овооны энгэр, Шандын гудамжууд, Аривжих хороолол, Боржигоны 10-25-р гудамж, хуучин колонк, Хүүхдийн парк

ЗАМЫН ХЯНАЛТЫН ЦЭГ БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙН

ХЯНАЛТЫН КАМЕР, ГЭРЭЛТҮҮЛЭГ

Мандалговь хотын гудамжны иж бүрэн телехяналтын системийн ажлыг тендерт шалгарсан “Смарт технологи” ХХК нь орон нутгийн хөгжлийн сангийн 708,0 сая төгрөгийн өртөг бүхий төсвийн хөрөнгөөр 2015.02.10-06.25-ны хооронд аймгийн төвийн 41 цэгт хөдөлгөөнт камер 15, чиглэлийн камер 47, нийт 62 ширхэг хяналтын камер суурилуулан ашиглалтанд бүрэн оруулж телехяналтын камерын системийн удирдлага болон ашиглалтыг цагдаагийн газарт хүлээлгэн өгч гүйцэтгэгч компанитай 3 жилийн баталгаат хугацаатай гэрээ байгуулан хүлээн авч үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

2020 оны 11 дүгээр сарын 19-ний байдлаар 62 ширхэг хяналтын камер ажиллахгүй гэмтэлтэй байна.

Дундговь аймгийн хэмжээнд замын хяналтын 2 цэг ажиллаж байна. Дундговь аймгийн Сайнцагаан сумын төв, Хулд сумын төв нийт 2 пост ажиллаж, 24 цагаар томилгоот алба хаагч нар гарч үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.



Сайнцагаан сумын хяналтын пост



Хулд сумын хяналтын пост

### ГЭРЭЛТҮҮЛГИЙН СУДАЛГАА /Сүүлийн 10 жилийн байдлаар/

№	Гудамж	Нийт шон	Ашиглалтанд орсон он	Гэмтэлгүй	Гэмтэлтэй
1	Айраг – 2	20	2008	20	
2	Арвижих зоогийн хөндлөн	11	2008	7	4
3	САХ – Нарлагийн өндөр	36	2008		36
4	Мандал – 8	25	2009		25
5	Айраг 9	28	2010	25	3
6	Айраг - 6	15	2010	15	
7	Боржигон-3	6	2010	5	1
8	Боржигон-10	24	2010	24	
9	Зах баруун талаас – Анужин	13	2010	13	
10	Боржигон-14	6	2012	6	
11	Боржигон-19	12	2012	11	1
12	Айраг 8	10	2013		10
13	Боржигон-12	11	2013	10	1
14	Боржигон-21	9	2013		9
15	Арвижих – 8	15	2013		15
16	Зоо – 4	10	2013	7	3

17	Аривжих-4	10	2014	3	7
18	Арвижих – 5	10	2014	2	8
19	Бүрд –Жаст	15	2014	15	
20	Бүрд – холбоо	13	2014	13	
21	Цаг уур -БМБК	10	2014	10	
22	Айраг – 1	12	2015	12	
23	Мандал - 1,2	23	2015	23	
24	Мандал – 5	27	2015	27	
25	Номгон	8	2015	8	
26	Мандал 9 – Жаст	25	2015	23	2
27	Айраг мандалын өргөн чөлөө	14	2015	14	
28	Жаст –Театр	23	2015	23	
29	Буянт гүүр – ардчилсан нам	25	2015	25	
30	Цаг уур – Бүгд	13	2015	10	3
31	Бүгд -Алтанговь	11	2015	11	
32	Мандал сургууль-Жаст	24	2016		24
33	Нарлаг – 7	10	2017		10
34	Чэгдаржав	8	2017	8	
35	Мандал – 12	28	2018	10	18
36	Мандал - 15	20	2018	17	3
37	Хүүхдийн парк БМБ	58	2018	58	
38	Зоогийн энгэр засмал	16	2019	16	
39	Залуус хороолол	30	2019		30
40	Буянт гүүр - МТ	27	2019		
41	Зоо – 8	8		5	3
	<b>Нийт</b>	<b>719</b>		<b>476</b>	<b>216</b>




## ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### НЭГ. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН БАЙДЛААР БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

#### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Цагдаагийн байгууллагад 2020 оны 10 дугаар сард иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гаргасан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 1334 гомдол мэдээлэл хүлээн авсныг урьд оны мөн үетэй харьцуулвал 132 гомдол мэдээллээр буюу 9 хувиар буурч, нийт шалгасан гомдол мэдээллийн 465 буюу 34,8 хувийг гэмт хэргийн, 869 буюу 65,2 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 465 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 60 гомдол мэдээллээр буюу 11,4 хувиар, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 869 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 72 гомдол мэдээллээр буюу 7,6 хувиар тус тус буурсан байна.


### Бүртгэгдсэн гомдол мэдээллийн тоо / сүүлийн 5 жилээр/




### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг

2020 оны эхний 10 дугаар сард Улсын хэмжээнд 21142 гэмт хэрэг бүртгэгдсэний 183 буюу 0,8 хувийг, Орон нутагт нийт 7728 гэмт хэрэг бүртгэгдсэний 2,3 хувийг Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеэс 5 хэргээр буюу 2,7 хувиар гэмт хэргийн гаралт буурсан байна.

### Бүх хэрэг / Аймагийн хэмжээнд/




#### 1.4 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг сумдаар



#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 148 буюу 80,8 хувь нь хөнгөн 35 буюу 19,2 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 1,4 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 16,6 хувиар тус тус буурсан байна.



## 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн бүлгээр


№	Үзүүлэлтүүд	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019.10 сар	2020.10 сар	Өнгөрсөн оны мөн үеэс				Эзлэх хувь
								Өсөлт		Бууралт		
								Тоо	Хувь	Тоо	Хувь	
	<b>Нийт гэмт хэрэг /Аймгийн хэмжээнд</b>	<b>221</b>	<b>216</b>	<b>266</b>	<b>211</b>	<b>188</b>	<b>183</b>			<b>5</b>	<b>2.7</b>	<b>0.8</b>
Үүнээс	Хүнийг санаатай алах гэмт хэрэг /10.1/	4	3	4								
	Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох /10.6/			1			1					
	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /12.1-12.5/	1	3	7	7	8	4			4	50	2.2
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх /10.4/	1	2		1	5	2			3	60	1.1
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /11.1-11.7/	<b>94</b>	<b>110</b>	<b>77</b>	<b>60</b>	<b>45</b>	<b>62</b>	<b>17</b>	<b>37.7</b>			<b>33.8</b>
	Өмчлөх эрхийн эсрэг /17.1-17.12/	<b>84</b>	<b>65</b>	<b>144</b>	<b>111</b>	<b>103</b>	<b>83</b>					
	Хулгайлах /17.1/	46	37	105	57	51	41			10	19.6	22.4
	Залилах /17.3/	10	3	10	17	17	17					9.3
	Хөрөнгө завших /17.4/	7	2	1	2	1	3	2	3 дахин			1.6
	Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших /17.5/		2	1	1	2	1			1	50	0.5
	Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх /17.8/	3	2	3	4	3	3					1.6
	Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх /17.11/		1									
	Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах /17.7/		1									
	Дээрэмдэх /17.2/	2	3	2	1	1	3	2	3 дахин			1.6
	Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх /17.6/			1								
Мал хулгайлах /17.12/	16	14	21	29	28	15			13	46.4	8.2	
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /15.1-15.6				1	1							0.5
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /16.1-16.11				1	1							0.5



### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг


Нийт үйлдэгдсэн гэмт хэргийг цагаар нь өмнөх оны мөн үетэй харьцуулж авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 1 буюу 2,8, 14-19 цагийн хооронд 12 буюу 21,8 хувиар тус тус буурч, 19-22 цагийн хооронд 5 буюу 23,8, 19-22 цагийн хооронд 3 буюу 3,8 хувиар тус тус өссөн байна.

Хэргийг гарагаар нь авч үзвэл: мягмар гарагт 1 буюу 3,3, пүрэв гарагт 4 буюу 16, баасан гарагт 3 буюу 10,7, бямба гарагт 6 буюу 22,2 тус тус буурч, даваа гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 3 буюу 12,5, лхагва гарагт 1 буюу 3,2, ням гарагт 5 буюу 22,7 хувиар тус тус өссөн байна.




### 1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр орон сууцанд үйлдэгдсэн 10 буюу 18,8, гудамж талбайд үйлдэгдсэн 12 буюу 70,6 хувиар тус тус өсч, олон нийтийн газар үйлдэгдсэн 2 буюу 40, төрийн байгууллагад үйлдэгдсэн 6 буюу 85,7, аж ахуй нэгж байгууллагад 1 буюу 12,5, бусад газар 10 буюу 12,5, авто замд 5 буюу 33,3 хувиар тус тус буурсан байна.




## 1.9 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 10,5 хувь, Бүлэглэн гүйцэтгэсэн-85,7 хувиар тус тус өсч Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 15,4 хувь, Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт 28,6 хувь, Хүүхэд оролцсон гэмт хэрэг 92,3 хувиар тус тус буурсан байна.




### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

**2.1** Аймгийн хэмжээнд Хэрэг бүртгэлтийн 166 хэрэг бүртгэгдсэнээс 82 хэрэгт яллагдагчаар татаж, гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 49,4 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 0,9 пунктээр буурсан статистик үзүүлэлттэй байна. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдээгүй үлдэгдэлтэй байгаа 84 гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 хэргээр буюу 3,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



## 15.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг


Хэрэг бүртгэлтийн нийт 166 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал 9 хэргээр буюу 5,2 хувиар, үүнээс 82 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6 хэргээр буюу 6,8 хувиар тус тус буурсан байна.




### Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

#### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 106 шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 буюу 9,3 хувиар өссөн. Гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 8 буюу 7,5 хувь нь эмэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 буюу 20 хувиар буурсан байна.




## Гэмт хэрэгт холбогдсон иргэдийн нийгмийн байдал /Сүүлийн 5 жилээр/



## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол


Гэмт хэргийн улмаас төр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 539,5 сая төгрөгийн хохирол учирсаны 237,9 сая төгрөг буюу 44,1 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн байна.

## Гэмт хэргийн улмаас нийт учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь /Сүүлийн 5 жилээр/



Гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 77 хүн гэмсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн ижил түвшинд, гэмтсэн хүн 20 буюу 35,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүний тоо / Сүүлийн 5 жилээр/




### Тав. Зөрчил


Дундговь аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд 2020 оны 10 сарын байдлаар нийт 16292 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1447 буюу 8,2 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 14591 буюу 89,5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1333 буюу 8,2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 30 буюу 0,2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зөрчих, 338 буюу 2,1 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан **16010** хүнийг **486,175** сая төгрөгөөр торгосон нь урьд оны мөн үетэй харьцуулахад 102,1 сая төгрөгөөр буурсан.

### Торгосон хүн төгрөг Сүүлийн 5 жилээр/



## Зөрчил гаргасан иргэдэд авсан арга хэмжээ Сүүлийн 5 жилээр



### Зургаа. Дүгнэлт:

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар бүртгэгдэн шалгагдсан гэмт хэргийн статистик тоон мэдээгээр нийт 1097 гэмт хэргийн шинжтэй үйлдэл бүртгэгдэн шалгагдсанаас Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 403 буюу 36.7 %-ыг, Хулгайлах гэмт хэрэг 286 буюу 26.1%-ыг, Малын хулгайн гэмт хэрэг 95 буюу 8.6%-ыг, Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 91 буюу 8.3%-ыг эзэлж байна. Дээрх хэргүүд нь 875 буюу нийт гэмт хэргийн 79.7%-ыг эзэлж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар өссөлттэй байгаа хэргүүдийг авч үзвэл: Хүчиндэх гэмт хэрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хулгайлах гэмт хэрэг, Залилах гэмт хэрэг, Мал хулгайлах гэмт хэрэг, Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргүүд өссөн үзүүлэлттэй байна.

Тоон мэдээгээр өссөн үзүүлэлттэй хэргүүдэд цагдаагийн газрын “Криминологи судалгааны баг”-аас гэмт хэргийн гаралтанд нөлөөлсөн шалтгаан нөхцлийг судалж, дүн шинжилгээ хийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулж ажиллаж байна.

Залилах гэмт хэргийн тухайд үйлдлийн арга цахим хэрэгсэл, фейсбүүк ашиглаж үйлдэх хэргийн тоо өссөн. Бүртгэгдэн шалгагдаж байгаа хэргүүдэд дүн шинжилгээ хийхэд гэмт хэргийн өсөлтөнд иргэдийн өөрсдийн гэнэн итгэмтгий зан, хуульзүйн мэдлэг тааруу, мэдлэг боловсрол бага, амар хялбар аргаар богино хугацаанд мөнгө олох гэсэн зорилго болон бусад хүчин зүйлүүдээс шалтгаалж байгаа нь тогтоогдсон. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2020 онд бүтэн жилийн хугацаанд “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээг зохион явуулж байна.

Хүчиндэх гэмт хэрэг 2010 оны 10 сарын байдлаар 8 бүртгэгдэн шалгагдсанаас эзэн холбогдогч тогтоогдоогүй хэрэг байхгүй. Энэ төрлийн гэмт хэрэг ахуйн хүрээнд үйлдэгдсэн бөгөөд өсвөр насны хүн хохирсон 2 тохиолдол шалгагдан шүүхээр хэрэг шийдвэрлэгдсэн. Хүчиндэх гэмт хэргээс урьдчилан, сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэр хариуцан ажиллаж байгаа сумдын хэсгийн мөрдөгч, цагдаа нараар иргэд, малчдад яриа хийлгэж, өсвөр насны хүүхэд өртөж хохирсон хэргүүдийг илрүүлэх чиглэлээр “Нуугдмал” арга хэмжээг зохион явуулж байна.

Мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр малчдын дунд зөвлөгөөн зохион байгуулж бүлэг нөхөрлөлийн тоог нэмэгдүүлэх, хяналтын пост нэмж ажиллуулах, аймгийн төвөөр дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслүүдийн дугаар илрүүлэгч ашиглах, гарал үүслийн гэрчилгээгүй мал, махан бүтээгдэхүүн худалдан борлуулсан, тээвэрлэсэн

тохиолдлуудыг илрүүлэн шалгах, иргэдээс гэмт этгээдүүдийн талаар төлбөртэй мэдээлэл авах, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллаж байна.

Дундговь аймагт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон иргэн, гэмт хэрэгт өртөж хохирсон иргэдийн тоо өссөн байгааг дээр дурьдсан.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйл бол ахуйн хүрээний архидалтаас үүдэлтэй юм. Архилан согтуурах явдалтай тэмцэх чиглэлээр аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундааны хэрэглэгээг бууруулах, архидалтаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор батлагдсан “Архидалтгүй аймаг-Дундговь дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн.

Хэрэг бүртгэх албанаас энэ оны 2 дугаар улиралд “Архигүй орчин” 1 сарын хугацаатай аяныг хариуцсан нутаг дэвсгэртээ зохион байгуулсан.

Цагдаагийн газраас Сайнцагаан сумын ИТХ, Улаанзагалмайн хороо, “Говийн хийморь” АА төвтэй хамтран “Архи ба ухаарал” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд аймгийн төвд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг 20 иргэн хамрагдсан.

Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоосонтой холбогдуулан аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах аж ахуй нэгжүүдэд цагийн хязгаар тогтоох, архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон аймгийн засаг даргын 2020 оны А/57, А/68, А/138 Сайнцагаан сумын засаг даргын 29, 42, 119 дүгээр захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж архи согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 116 хүнсний дэлгүүр, зоогийн газруудад засаг даргын захирамжийг хүргүүлж, архи согтууруулах ундааг агуулахад хийлгэж лацадсан.

Мөн “Гэр бүлийн өдөр”, “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан аймаг, сумдын засаг даргын захирамж гаргуулж биелэлтэд нь хяналт тавьсан.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1470 иргэн, гэмт хэрэг, зөрчилд шалгагдаж байгаа 11 холбогдогч, захиргааны хяналтад байгаа 6, баривчлагдсан 21 иргэн “Архидан согтуулахтай тэмцэх” тухай хууль, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай” хуулиар сургалт зохион байгуулж архи, тамхины хэрэглээнээс татгалзах 6 төрлийн санамж, сэрэмжлүүлгийг дээрх иргэдэд тараан сурталчилсан.

Цаашид аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 62,8 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд эзэлж байна.

Дээрх гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэхэд гол анхааралаа хандуулан ажиллаж байна.

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН:

МЭРГЭЖИЛТЭН Г.АРИУНЖАРГАЛ